ЗАВХАН АЙМАГ ДАХЬ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Их-Уул сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: ЗАА-2022/15/СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улиастай хот<br>2022 он | Дарга, Тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа<br>Утас: 70463612 Цахим хаяг: batundraa@audit.gov.mn<br>Ахлах аудитор : Б.Дагвасүрэн<br>Утас:99014227 Цахим хаяг:dagvasurenb@audit.gov.mn<br>Аудитор П.Ганцолмон<br>Утас:70157405 Цахим хаяг:uliastaivanaudit@ubaudit.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Агуулга**

1. **Аудитын санал дүгнэлт** ........ 2

2. **Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл**

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ........ 4

2.2 Аудит хийсэн үр дүнгийн тайлан ........ 5

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ........ 7

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ........ 8

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ........ 10

3. **Аудитын тайлан**

3.1 Ерөнхий зүйл ........ 12

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ........ 12

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ........ 12

3.4 Материаллаг байдал ........ 13

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ........ 13

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ........ 14

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ........ 14

3.8 Аудитын гол асуудал ........ 14

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал, Шилэн дансны хуулийн хэрэгжилт, бусад хууль тогтоомж ........ 14

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........ 15

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал ........ 15

4. **Аудитын илрүүлэлт** ........ 15

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

## 1. Төрийн аудитын санал, дүгнэлт

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
81090 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс:7046-36-12

2022.02.24 № 1302/334

танай ________ -ны № ________ -т

ИХ-УУЛ СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА И.БАТЖАРГАЛ -д

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу дагуу Их-Уул сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол дагуу Их-Уул сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

*4.8 сая төгрөгийн зардлыг зориулалт бусаар зарцуулсан, 13.5 сая төгрөгийн худалдан авалтын и баримтыг бүрдүүлээгүй зэрэг зөрчил нь* (Төсвийн тухай хуулийн 16.5.5; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7; Татварын ерөнхий хуулийн 28.2; Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3 дахь заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй) *байна.*

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

01?025378

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Д.БАТ-УНДРАА

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
## 2.1 Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 105,626,520.22 | 159,144,649.22 |
| 33 | АВЛАГА | 31,188,606.00 | 62,607,800.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 536,006.00 | - |
| 335 | Бусад авлага | 30,652,600.00 | 62,607,800.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | - | 30,000,000.00 |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 30,652,600.00 | 32,607,800.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 74,437,914.22 | 96,536,849.22 |
| 351 | Түүхий эд материал | 4,205,009.22 | 10,485,009.22 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 4,205,009.22 | 10,485,009.22 |
| 354 | Хангамжийн материал | 63,447,305.00 | 79,213,840.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,268,400.00 | 2,246,500.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 58,812,805.00 | 70,079,480.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 3,366,100.00 | 5,789,860.00 |
| 35450 | Барилгын засварын материал | - | 1,098,000.00 |
| 35600 | Мал амьтад | 6,785,600.00 | 6,838,000.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 558,731,953.10 | 609,812,087.20 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 558,731,953.10 | 609,812,087.20 |
| 392 | Биет хөрөнгө | 527,585,953.10 | 579,146,087.20 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 415,257,253.18 | 455,257,253.18 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (100,947,764.77) | (120,880,123.33) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 224,399,800.00 | 244,499,800.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (185,831,342.56) | (192,411,552.40) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 203,038,391.00 | 220,058,391.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (170,706,719.08) | (183,572,035.40) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 26,257,183.00 | 26,257,183.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (19,527,102.31) | (20,775,227.95) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 211,494,344.00 | 242,184,344.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (76,112,089.36) | (91,735,944.90) |
| 39217 | Ном | 264,000.00 | 264,000.00 |
| 393 | Биет бус хөрөнгө | 31,146,000.00 | 30,666,000.00 |
| 39301 | Програм хангамж | 3,552,000.00 | 3,552,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (1,392,000.00) | (1,872,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 28,986,000.00 | 28,986,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 664,358,473.32 | 768,956,736.42 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 664,358,473.32 | 768,956,736.42 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 664,358,473.32 | 768,956,736.42 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 388,066,377.00 | 388,066,377.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 388,066,377.00 | 388,066,377.00 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 86,626,195.06 | 191,224,458.16 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 86,626,195.06 | 86,626,195.06 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 104,598,263.10 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 189,665,901.26 | 189,665,901.26 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 664,358,473.32 | 768,956,736.42 |

## 2.2 Аудит хийсэн Санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **473,516,575.22** | **750,544,208.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **35,354,929.22** | **194,722,200.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 35,354,929.22 | 194,722,200.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 35,354,929.22 | 194,722,200.00 |
| 1E+06 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 26,000,000.00 | 131,191,000.00 |
| 1E+06 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 9,354,929.22 | 63,531,200.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **438,161,646.00** | **555,822,008.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 395,620,500.00 | 389,925,760.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 395,620,500.00 | 389,925,760.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 42,541,146.00 | 165,896,248.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, | 14,460,400.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 14,897,446.00 | 136,997,999.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон | 13,183,300.00 | 28,898,249.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **531,265,574.26** | **645,945,944.90** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **531,265,574.26** | **645,945,944.90** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 482,702,126.26 | 593,144,453.90 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 267,773,442.00 | 271,307,957.00 |
| 210101 | Үндсэн цалин | 238,917,029.00 | 211,146,164.00 |
| 210102 | Нэмэгдэл | - | 30,466,851.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 28,856,413.00 | 29,694,942.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 31,776,880.00 | 35,570,571.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 22,101,612.00 | 24,734,567.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,600,190.00 | 2,759,360.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,066,712.00 | 2,207,488.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 431,602.00 | 528,978.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,576,764.00 | 5,340,178.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 7,680,206.00 | 6,932,768.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,867,745.00 | 3,566,668.00 |
| 210302 | Түлш, халаалт | 4,812,461.00 | 3,366,100.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 44,231,843.70 | 64,786,022.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,583,950.00 | 7,434,450.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 35,226,331.70 | 29,475,197.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,686,402.00 | 2,593,750.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,735,160.00 | 25,282,625.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,633,500.00 | 6,001,350.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,633,500.00 | 6,001,350.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 5,077,000.00 | 5,126,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 5,077,000.00 | 5,126,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 31,181,187.00 | 40,706,810.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр | 29,233,266.00 | 38,929,705.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 232,100.00 | 500,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 469,100.00 | 469,100.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 227,700.00 | 227,700.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 73,800.00 | 73,800.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 562,021.00 | 129,621.00 |
| 210807 | Газрын төлбөр | 367,500.00 | 361,184.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 15,700.00 | 15,700.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 92,348,067.56 | 162,712,975.90 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 20,607,555.00 | 98,083,110.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 25,300.00 | - |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 71,715,212.56 | 64,629,865.90 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 48,563,448.00 | 52,801,491.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 31,028,700.00 | - |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 31,028,700.00 | - |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 12,179,088.00 | - |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 12,179,088.00 | - |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 5,355,660.00 | 52,801,491.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 5,355,660.00 | 52,801,491.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(57,748,999.04)** | **104,598,263.10** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(57,748,999.04)** | **104,598,263.10** |

## 2.3 Аудит хийсэн Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **388,066,377.00** | **189,665,901.26** | **144,375,194.10** | **722,107,472.36** |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **388,066,377.00** | **189,665,901.26** | **144,375,194.10** | **722,107,472.36** |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | - | - | - | - |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | - | - | - | - |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | (57,748,999.04) | **(57,748,999.04)** |
| C08 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **388,066,377.00** | **189,665,901.26** | **86,626,195.06** | **664,358,473.32** |
| D01 | **2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **388,066,377.00** | **189,665,901.26** | **86,626,195.06** | **664,358,473.32** |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **388,066,377.00** | **189,665,901.26** | **86,626,195.06** | **664,358,473.32** |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, | - | - | - | - |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 388,066,377.00 | 189,665,901.26 | 86,626,195.06 | **664,358,473.32** |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - | - | - |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | 104,598,263.10 | **104,598,263.10** |
| D09 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **388,066,377.00** | **189,665,901.26** | **191,224,458.16** | **768,956,736.42** |

## 2.4 Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **464,161,646.00** | **687,013,008.00** |
| 12 | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **26,000,000.00** | **131,191,000.00** |
| 120 | **Нийтлэг татварын бус орлого** | 26,000,000.00 | 131,191,000.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 26,000,000.00 | 131,191,000.00 |
| 1200043 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 26,000,000.00 | 131,191,000.00 |
| 13 | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **438,161,646.00** | **555,822,008.00** |
| 1310 | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 395,620,500.00 | 389,925,760.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 395,620,500.00 | 389,925,760.00 |
| 1311 | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 42,541,146.00 | 165,896,248.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 14,897,446.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 14,460,400.00 | 136,997,999.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 13,183,300.00 | 28,898,249.00 |
| 2 | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **462,511,646.00** | **599,303,008.00** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **462,511,646.00** | **599,303,008.00** |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **413,948,198.00** | **546,501,517.00** |
| 2101 | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 264,439,328.00 | 270,196,622.00 |
| 210101 | Үндсэн цалин | 244,738,919.00 | 252,724,003.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 19,700,409.00 | 17,472,619.00 |
| 2102 | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 35,647,000.00 | 36,481,900.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 25,084,900.00 | 25,672,400.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,640,500.00 | 2,702,400.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,144,200.00 | 2,161,900.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 496,400.00 | 540,500.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,281,000.00 | 5,404,700.00 |
| 2103 | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 11,046,306.00 | 12,034,040.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,667,745.00 | 3,566,668.00 |
| 210302 | Түлш, халаалт | 7,378,561.00 | 8,467,372.00 |
| 2104 | **Хангамж, бараа материалын зардал** | 42,250,187.00 | 31,887,700.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 4,815,990.00 | 5,280,350.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 31,952,920.00 | 22,209,600.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 5,481,277.00 | 4,397,750.00 |
| 2105 | **Нормативт зардал** | | 2,000,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | | 2,000,000.00 |
| 2106 | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,773,500.00 | 14,915,450.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | | 6,600,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,773,500.00 | 8,315,450.00 |
| 2107 | **Томилолт, зочны зардал** | 5,077,000.00 | 5,126,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 5,077,000.00 | 5,126,000.00 |
| 2108 | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 28,297,387.00 | 127,077,695.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 26,349,466.00 | 125,300,590.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 232,100.00 | 500,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 469,100.00 | 469,100.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 227,700.00 | 227,700.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 73,800.00 | 73,800.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 562,021.00 | 129,621.00 |
| 210807 | Газрын төлбөр | 367,500.00 | 361,184.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 15,700.00 | 15,700.00 |
| [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] |

| | | | |
|---|---|---|---|
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 24,417,490.00 | 46,782,110.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 24,392,190.00 | 46,479,010.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 25,300.00 | 303,100.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 48,563,448.00 | **52,801,491.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 31,028,700.00 | - |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | **31,028,700.00** | - |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 12,179,088.00 | - |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 12,179,088.00 | - |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **5,355,660.00** | **52,801,491.00** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | **5,355,660.00** | 52,801,491.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **1,650,000.00** | **87,710,000.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | 1,650,000.00 | **87,710,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | 1,650,000.00 | **87,710,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 1,650,000.00 | 87,710,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 1,650,000.00 | 87,710,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(1,650,000.00)** | **(87,710,000.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | - | - |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | - |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | - |

## 2.5 Аудит хийсэн Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 574,023,200.00 | 500,320,877.00 | 73,702,323.00 | 87% |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 574,023,200.00 | 500,320,877.00 | 73,702,323.00 | 87% |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 574,023,200.00 | 500,320,877.00 | 73,702,323.00 | 87% |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 270,236,100.00 | 270,196,622.00 | 39,478.00 | 100% |
| 210101 | Үндсэн цалин | 243,880,900.00 | 252,724,003.00 | (8,843,103.00) | 104% |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 26,355,200.00 | 17,472,619.00 | 8,882,581.00 | 66% |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 36,481,900.00 | 36,481,900.00 | - | 100% |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 25,672,400.00 | 25,672,400.00 | - | 100% |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,702,400.00 | 2,702,400.00 | - | 100% |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,162,400.00 | 2,161,900.00 | 500.00 | 100% |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 540,000.00 | 540,500.00 | (500.00) | 100% |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,404,700.00 | 5,404,700.00 | - | 100% |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 12,046,400.00 | 12,034,040.00 | 12,360.00 | 100% |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,446,400.00 | 3,566,668.00 | 879,732.00 | 80% |
| 210302 | Түлш, халаалт | 7,600,000.00 | 8,467,372.00 | (867,372.00) | 111% |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 31,939,400.00 | 31,887,700.00 | 51,700.00 | 100% |
| 210401 | Бичиг хэрэг | 5,357,200.00 | 5,551,250.00 | (194,050.00) | 104% |
| 210402 | Тээвэр, шатахуун | 20,242,400.00 | 21,938,700.00 | (1,696,300.00) | 108% |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 6,339,800.00 | 4,397,750.00 | 1,942,050.00 | 69% |
| **2105** | **Норматив зардал** | - | 2,000,000.00 | (2,000,000.00) | |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | - | 2,000,000.00 | (2,000,000.00) | |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 17,773,500.00 | 15,771,850.00 | 2,001,650.00 | 89% |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 15,000,000.00 | 13,000,000.00 | 2,000,000.00 | 87% |
| 210604 | Урсгал засвар | 2,773,500.00 | 2,771,850.00 | 1,650.00 | 100% |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 5,614,500.00 | 5,126,000.00 | 488,500.00 | 91% |
| 210702 | Дотоод албан томилолт | 5,614,500.00 | 5,126,000.00 | 488,500.00 | 91% |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 175,828,000.00 | 96,129,205.00 | 79,698,795.00 | 55% |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 173,700,000.00 | 94,352,100.00 | 79,347,900.00 | 54% |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 500,000.00 | 500,000.00 | - | 100% |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 469,100.00 | 469,100.00 | - | 100% |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 227,700.00 | 227,700.00 | - | 100% |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 73,800.00 | 73,800.00 | - | 100% |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 203,400.00 | 129,621.00 | 73,779.00 | 64% |
| 210807 | Газрын төлбөр | 638,300.00 | 361,184.00 | 277,116.00 | 57% |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 15,700.00 | 15,700.00 | - | 100% |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 24,103,400.00 | 30,693,560.00 | (6,590,160.00) | 127% |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 23,800,000.00 | 30,390,460.00 | (6,590,460.00) | 128% |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 303,400.00 | 303,100.00 | 300.00 | 100% |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 311,434,400.00 | 521,116,760.00 | (209,682,360.00) | 167% |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 311,434,400.00 | 521,116,760.00 | (209,682,360.00) | 167% |
| 122005 | Орон нутгийн төсвөөс | 91,846,500.00 | 521,116,760.00 | (429,270,260.00) | 567% |
| 132004 | Оны эхний үлдэгдэлээс санхүүжих /орон нутаг/ | 219,587,900.00 | - | 219,587,900.00 | 0% |

## 2.6 Аудит хийсэн Нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **133,890,640.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **133,890,640.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 133,890,640.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 5,543,600.00 |
| 210604 | Урсгал засвар | 5,543,600.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 95,811,090.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 95,811,090.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 32,535,950.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 32,535,950.00 |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **32,005,608.00** |
| 213403 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг | 32,005,608.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 165,896,248.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 165,896,248.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 136,997,999.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 28,898,249.00 |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Их-Уул сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Улиастай ван аудит ХХК-ийн ахлах аудитор П.Ганцолмон, аудитор Д.Гэрэлхүү нар гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Б.Дагвасүрэн, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар хэрэгжүүлсэн.

Их-Уул сумын ЗДТГ-т 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газарт 2022 оны 01 дугаар сарын 21-ны өдрийн 03/22 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Их-Уул сумын ЗДТГ нь сумын Засаг даргын үйл ажиллагаанд мэргэжил, арга зүй, зохион байгуулалтын туслалцаа үзүүлж,ажиллах нөхцөл бололцоогоор хангахын зэрэгцээ цаг үеэ олсон,мэргэжлийн зөвлөгөө,дэмжлэгээр шуурхай хангах замаар хууль тогтоомж, бусад эрх зүйн хэм хэмжээний акт, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг сумын нутаг дэвсгэрт бүрэн дүүрэн хэрэгжүүлэх үндсэн чиг үүрэг бүхий ажлын алба юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна. Их-Уул сумын ЗДТГ нь дотоод аудитын нэгж байхгүй.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Их-уул сумын ЗДТГ нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны эхний хагас жилийн нийт орлого 446,855.4 мянган төгрөгийн 1 хувиар буюу 4,468.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 3,127.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн материаллаг байдлыг 2021 оны нийт орлого 750,544.2 мянган төгрөгийн 1 хувь буюу 7,505.4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг түүний 70 хувь буюу 5,253.8 мянган төгрөгөөр тогтоосон.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Авлага | 31,188.6 | 62,607.8 | 31,419.2 |
| Бараа | 74,437.9 | 96,536.9 | 22,099.0 |
| Үндсэн хөрөнгө | 558,731.9 | 609,812.0 | 51,080.1 |
| **Нийт хөрөнгө** | **664,358.4** | **768,956.7** | **104,598.3** |
| Өр төлбөр | - | - | - |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 664,358.4 | 768,956.7 | 104,598.3 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө** | **664,358.4** | **768,956.7** | **104,598.3** |

Авлага дансны үлдэгдэл 31,419.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь зориулалт бус зарцуулалттай холбоотой байна. Энэ нь хувь хүмүүстэй холбоотой авлага байна.

Бараа материалын данс 22,099.0 мянган төгрөгөөр өссөн нь бараа материалын дансанд хандив тусламжаар 35,478.8 мянган төгрөгийн тусгай зориулалтын бараа материал нэмэгдсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн данс 51,080.1 мянган төгрөг болж өссөн нь тайлант онд 115,710.0 мянган төгрөгөөр үндсэн хөрөнгө нэмэгдсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 104,598.3 мянган төгрөг болж өссөн нь тайлант үеийн үр дүн өссөнтэй холбоотой байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 574,023.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлж батлуулсан байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 521,116.7 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, урсгал үйл ажиллагаанд 500,321. мянган төгрөгийг зарцуулж, улсын төсөвт 20,795.8 сая төгрөгийг төвөлрүүлсэн.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар 165,896.2 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэн, эд хогшил худалдан авах зардалд 5,543.6 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 95,811.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний зардалд 32,535.9 мянган төгрөгийг тус тус зарцуулан, үлдэгдэл 32,005.6 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Онцолсон болон бусад асуудал гараагүй.

### 3.8 Аудитын гол асуудал

Онцолсон болон бусад асуудал гараагүй.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын  2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 149 мэдээллээс 140 мэдээллийг хугацаандаа мэдээлсэн ба хугацаа хоцроосон мэдээлэл 9 байна.

Хугацаа хоцроосон 9 мэдээлэл нь Нийтийн ашиг сонирхол, хувийн ашиг сонирхлыг зохицуулах тухай, бонд, өрийн бичиг баталгаа, төвлөрүүлэх орлогын тайлан мэдээлэл байна. Байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжиийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 2 зөвлөмж хүргүүлснийг хэрэгжүүлсэн байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Монгол Улсын ЗГ-ын 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим Сангийн сайдын 2012 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн Дугаар 276 дугаар тушаалын хавсралт " Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам"-ыг мөрдөж ажиллах.

"Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ.", мөрдөж ажиллах.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 42,544.5 мянган төгрөгийн зөрчлийг илрүүлэн,15,804.0 мянган төгрөгийн зөрчилд залруулга хийж, 21,940.5 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж хүргүүлж, 4,800.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүллээ.

**4.1 Залруулсан алдаа:** Цэцэрлэгт хүрээлэнгийн хайс, шинээр барсан гүүрнүүд орлогот аваагүй болович 100% буюу 11,800.0 мянган төгрөгийг шилжүүлсэн, мөн 3-р улирлаар гаргасан санхүүгийн тайлан тайлангийн үр дүнгийн цалин хөлс, 199,099.2 төгрөг, НДШ 26,028.5 төгрөг , мөнгөн гүйлгээний цалин хөлс 202,674.4 төгрөг, НДШ 27,361.8 төгрөг авлагын тайланд тусгасан дүн 5,597.6 төгрөг гэж тайлагнасан нь тулган баталгаажуулалтаар 4,004,051 төгрөгийн зөрүүтэй тайлагнасныг тус тус залруулсан.

### 4.2 Төлбөр тогтоогоогүй

### 4.3 Албан шаардлага:

- ✓ *Илрүүлэлт:* 6 сарын 25-нд Орон нутгийн өмчийн газраас Ланд машины засварт гэж 4,800.0 мянган төгрөгний орлогыг Онцгой комисс, шуурхай штабынханд урамшуулалаар олгосон зөрчилд албан шаардлага хүргүүлж байна.

- ✓ <u>Өгсөн албан шаардлага</u>: Завхан аймгийн ИТХ-ийн Тэргүүлэгчдийн 2018 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 25 дугаар тогтоолоор батлагдсан "Орон нутгийн өмчит

хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам"-ын 6 дугаар бүлгийн 6.6 дахь /Өмч борлуулсны орлогоос орон нутагт төвлөрсөн орлогын 30 хувийг аймгийн ИТХ-ын байгууллагын дансанд төвлөрүүлж ИТХ-ын шийдвэрээр зарцуулна/ гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах.

**4.4 Зөвлөмж:**

**1.Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал**

- ✓ Илрүүлэлт**:** 8,548.8 мянган төгрөгийг няравын дансаар дамжуулан зарцуулахдаа гэрэл цахилгаан, ус, засвар, бараа материалд зарцуулсан нь жижиг мөнгөн сан, кассын журам зөрчсөн
- ✓ Өгсөн зөвлөмж: Сангийн сайдын 2012 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн Дугаар 276 дугаар тушаалын хавсралт " Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам"-ыг мөрдөж ажиллах.

**1. Татвартай холбоотой асуудал**

- ✓ Илрүүлэлт: Тайлант хугацаанд 95,177.5 мянган төгрөгийн худалдан авалт хийснийг и баримтын цахим бүртгэлтэй тулгахад 13,355.7 мянган төгрөгийн гүйлгээ нь и баримтгүй байгаа нь нотлогдлоо.
- ✓ Зөвлөмжийн үндэслэл: И баримтыг бүрдүүлээгүй зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно"; Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ."; Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ." гэж заасныг хэрэгжүүлэн ажиллах.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**2. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Их-уул сумын ЗДТГ | 5 | 42.5 | 2 | 15.8 | - | - | 1 | 4.8 | 2 | 21.9 |